



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/НЧ5

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүгийн тухай хуулийн 15.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, нөхөн олгох журам"-ын 5.6 дах заалт, Увс аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 06 дугаартай магадлал, Увс аймаг дах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 2/949 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний бага эмч Мидэрийн Алтанхуягийн БЭ0005450 сери, 0005450 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс гурван жилийн хугацаагаар хүчингүй болгосугай.

2. Хүний бага эмч М.Алтанхуягийн эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай:


2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр олгох эрх үүстэл буюу 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;

2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл /С.Сонин/, Увс аймгийн Эрүүл мэндийн газар /Ц.Отгонбаяр/, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо /Ц.Ганхүү/, Увс аймаг дах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /Д.Даваажав/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081758